



СЭЛЭНГЭ АЙМАГ
ЖАВХЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 438

Жаргалант

Г

Г

Ажлын цагт зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.а, Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2, 23 дугаар зүйлийн 23.3, 32 дугаар зүйлийн 32.1.8, 34 дүгээр зүйлийн 34.2.2, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 6 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/82 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирус /COVID-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 30-ны өдрийг дуустал хугацаанд жирэмсэн болон 0-12 насны хүүхэдтэй эх /өрх толгойлсон эцэг/ ажилтан, албан хаагчийг гэрээсээ ажиллах нөхцөл боломжоор хангах, цалинтай чөлөө олгох зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг албан байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад даалгасугай.

2. Төрийн албаны тасралтгүй байдлыг хангаж, албан үүргийг бүрэн гүйцэтгүүлэх, байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, ажлын цаг ашиглалтыг үр бүтээлтэй хангаж, хэрэгжүүлсэн ажлын тайлангаа тухай бүр тайлагнаж ажиллахыг албан байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Бямбадалай/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ОТГОНДАЛАЙ

